



**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ТУШААЛ**

2018 оны 11 сарын 06 өдөр

Дугаар 340

Улаанбаатар хот

Хариуцлагатай жижүүр, эргүүл томилох тухай

Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8 дахь хэсэг, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8 дахь заалт, Зам, тээврийн хөгжлийн яамны “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 8.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Их Эзэн Чингис хааны өдөр”-өөр ажиллах хариуцлагатай жижүүр, эргүүлийн нэрс, ажиллах цагийн хуваарийг нэгдүгээр хавсралтаар ажлын удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Баярын амралтын өдрүүдэд зам, тээврийн салбарын байгууллагууд болон иргэдээс ирүүлсэн мэдээллийг шуурхай бүртгэн хүлээн авч, холбогдох байгууллага, албан тушаалтанд нэн даруй мэдээлж, шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг хариуцлагатай жижүүрт, байгууллагынхаа хэмжээнд хариуцлагатай жижүүрийг томилон ажиллуулж, зам тээврийн салбарын шуурхай бэлэн байдлыг ханган, холбогдох мэдээллийг яамны хариуцлагатай жижүүрт шуурхай мэдээлж ажиллахыг тус яамны харьяа төрийн байгууллага, төрийн өмчит компани, улсын төсөвт үйлдвэрийн газрын дарга, захирал нарт тус тус үүрэг болгосугай.


3. Баярын өдрүүдэд ажиллах хариуцлагатай жижүүрүүдэд ажлын чиглэл, зааварчилгаа өгч, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Ж.Гантөмөр/-т, нийтээр тэмдэглэх баярын өдрүүдэд ажилласан албан хаагчдыг нөхөн амрах ажлыг зохион байгуулахыг газар, хэлтсийн дарга нарт тус тус даалгасугай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Р.МЭРГЭН



081231

Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 390 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



**ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ХАРИУЦЛАГАТАЙ
ЖИЖҮҮРИЙН НЭРС, АЖИЛЛАХ ЦАГИЙН ХУВААРЬ**

№	Жижүүрийн нэрс	Газар, хэлтэс	Утасны дугаар	Жижүүр хийх		Эргүүлийн нэр	Холбоо барих утас
				Өдөр	Цаг		
1.	Б.Дархандарьяа	АЗБХЗГ-ын мэргэжилтэн	99059320	11.08	08.00-14.00	ТЗБХ-ийн дарга Г.Гантулга	88176363
2.	Т.Мягмарсүрэн	АТБХЗГ-ын мэргэжилтэн	95899555	11.08	14.00-20.00		
3.	Ц.Халиун	ГХАХ-ийн мэргэжилтэн	99068505	11.09	08.00-14.00	ГХАХ-ийн дарга Б.Болор-Эрдэнэ	91114576
4.	А.Оюунболд	ТЗУГ-ын мэргэжилтэн	99055640	11.09	14.00-20.00		
5.	Б.Батнасан	ТЗДТБХЗГ-ын мэргэжилтэн	99245455	11.10	08.00-14.00	ДАУЗТХ-ийн дарга Д.Жавхлан	99106458
6.	М.Батмягмар	ТЗДТБХЗГ-ын мэргэжилтэн	99050285	11.10	14.00-20.00		
7.	Н.Уугандулам	ХШУДАГ-ын мэргэжилтэн	88013058	11.11	08.00-14.00	ЗТХХ-ийн ахлах мэргэжилтэн Д.Энх-Амгалан	99441138
8.	Б.Дэлгэрдалай	БТГ-ын ахлах мэргэжилтэн	80096009	11.11	14.00-20.00		

Жич:

1. Зам, тээврийн хөгжлийн яамны мэдээ хүлээн авах утас: 62263179
2. Төрийн ордны онцгой байдлын албаны 51-260545 дугаар утсанд 2 цаг тутам мэдээлэл өгнө.

Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны 11 дүгээр сарын 06 ны өдрийн 370 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ХАРИУЦЛАГАТАЙ ЖИЖҮҮР, ЭРГҮҮЛИЙН АЖЛЫН УДИРДАМЖ

Яамны хариуцлагатай жижүүр, эргүүл нь 2018 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 08.00 цагаас эхлэн 2018 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 20.00 цаг хүртэлх хугацаанд дараах удирдамжийн дагуу ажиллана.

1. Яамны хариуцлагатай жижүүр нь угтах үйлчилгээний ажилтны ажлын байран дээр байрлаж, 62263179 утсаар мэдээллийг хүлээн авна.

2. Хариуцлагатай жижүүр нь өөрийн хуваарьт хугацаанд өндөр хариуцлагатай ажиллаж, утасны дуудлага бүрд шуурхай хариу өгч, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын шуурхай жижүүр, Онцгой байдлын ерөнхий газартай холбоотой ажиллана.

3. Хариуцлагатай жижүүр нь цаг агаарын мэдээллийг хүлээн авч, болзошгүй байгалийн гамшиг, гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахыг харьяа агентлаг, газруудад анхааруулна.

4. Харьяа салбарын байгууллагуудын хариуцлагатай жижүүр болон бусад эрх бүхий албан тушаалтантай холбоотой ажиллаж, цаг үеийн байдлын талаарх мэдээ, мэдээллийг солилцож, мэдээллийг нэгтгэн эргүүл болон холбогдох албан тушаалтанд тухай бүр танилцуулна.

5. Мэдээллийг төрийн ордны онцгой байдлын албаны 51-260545 дугаар утсанд 2 цаг тутамд тогтмол өгнө.

6. Хариуцлагатай жижүүр, эргүүл нь байгалийн гамшиг, гэнэтийн осол болон салбарын хэвийн үйл ажиллагаанд нөлөөлөх асуудал гарвал Сайд, Дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга, холбогдох газрын даргад шуурхай мэдээлж, удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу шаардлагатай арга хэмжээг цаг тухайд нь нэн даруй авч ажиллана.

7. Хариуцлагатай эргүүл нь яамны хариуцлагатай жижүүр болон харьяа байгууллагуудын хариуцлагатай жижүүрийн үйл ажиллагааг давхар хянаж ажиллана.

8. Хариуцлагатай эргүүл нь 2 цаг тутам хариуцлагатай жижүүртэй холбогдож мэдээлэл авч, үүрэг чиглэл өгөхийн зэрэгцээ Төрийн захиргааны удирдлагын газрын даргад цагийн байдлыг илтгэнэ.

9. Хариуцлагатай жижүүр нь харьяа салбарын болон бусад байгууллага, иргэдээс өгсөн шуурхай мэдээ, мэдээллийг нэг бүрчлэн цаг хугацаа, мэдээлсэн эзэнтэй нь тодорхой тэмдэглэж, бүртгэл хөтлөх бөгөөд мэдээллийн мөрөөр авсан арга хэмжээний талаар бүртгэлийн дэвтэрт тэмдэглэнэ.

10. Хариуцлагатай жижүүр нь хуваарьт хугацаандаа үүрэг гүйцэтгэсэн байдал, холбоо барьсан хүмүүс, ирсэн мэдээ, мэдээлэл, түүнийг хэрхэн шийдвэрлэсэн тухай болон цаашид анхаарах асуудлын талаар дэлгэрэнгүй тайлан бичиж дараагийн жижүүрт холбогдох баримт бичгийн хамт хүлээлгэн өгнө.

11. Хуваарийн дагуу хамгийн сүүлд ажилласан хариуцлагатай жижүүр нь өмнөх жижүүрүүдийн тайланд үндэслэн нэгдсэн тайлан бичиж, Төрийн захиргааны удирдлагын газрын даргад танилцуулна.